


Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

Монголын хөрөнгийн бирж ХК

2024 оны 12 дугаар сарын 31



АГУУЛГА

Компанийн талаарх мэдээлэл	2
Удирдлагын мэдэгдэл	3
Хараат бус аудиторын дүгнэлт	4
Санхүүгийн байдлын тайлан	7
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	9
Өмчийн өөрчлөлтийн тайлан	10
Мөнгөн гүйлгээний тайлан	11
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	13
1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл	13
2. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал	13
3. Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд	14
4. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд	14
5. Санхүүгийн тайлангийн дахин тайлагнал	20
6. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр	20
7. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	21
8. Дансны болон бусад авлага	22
9. Үндсэн хөрөнгө	23
10. Биет бус хөрөнгө	24
11. Дансны ба бусад өглөг	25
12. Урьдчилж орсон орлого	26
13. Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дэнчингийн өглөг	26
14. Биржийн эрсдэлийн сан	27
15. Хойшлогдсон орлогын албан татвар	27
16. Капитал ба нөөц	28
17. Үйлчилгээний орлого	29
18. Үйлчилгээний өртөг	30
19. Хүүгийн орлого	31
20. Бусад орлого /зардал	31
21. Борлуулалт, маркетингийн зардал	31
22. Ерөнхий ба удирдлагын зардал	32
23. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	32
24. Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	33
25. Орлогын татварын зардал/(нөхөлт)	33
26. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	33
27. Холбоотой талын ажил гүйлгээ	34
28. Болзошгүй өр төлбөр	34
29. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл	34
30. Бодит үнэ цэнийн хэмжилт	38
31. Капиталын удирдлагын бодлого, журам	40
32. Тайлагналын үеийн дараах үйл явдал	40
33. Орчуулга	40
34. Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт	40

Компанийн талаарх мэдээлэл

Компанийн нэр:	Монголын хөрөнгийн бирж ХК	
Үүсгэн байгуулах шийдвэр:	Монголын хөрөнгийн бирж ХК нь 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр анх үүсгэн байгуулагдсан.	
Гэрчилгээ ба лиценз	Монгол Улсын Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж 2071096 тоот регистр бүхий 9012001021 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 330 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 330/01 тоот гэрчилгээ авсан.	
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн	Овог нэр	Албан тушаал
- Дарга	Д.Тогтохбаяр	МУБИС-ийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
- Гишүүд	С.Баянцогт	"Алтайн зам" ХК-ийн Санхүүгийн хэлтсийн захирал
	Ж.Бямбасүрэн	ЗГХЭГ-ын Санхүү, эдийн засгийн газрын дарга
	Т.Ганбаатар	УУХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга
	Ж.Цогтбаяр	Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн дарга
- Хараат бус гишүүд	М.Банзрагч	ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн Сургалт, чанарын албаны дарга
	Р.Мөнхтөр	"Айкор партнерс" ХХК-ийн Дэд захирал
	Н.Отгончимэг	"Сүлд-Аудит" ХХК-ийн Аудитор
	Н.Улаанхүү	Ландбридж" ХХК-ийн Санхүү, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал
Удирдлагын баг:	Б.Дөлгөөн	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Х.Эрдэнэбүрэн	Захиргаа, санхүүгийн газрын захирал
	И.Жавхлан	Үйл ажиллагааны газрын захирал
	А.Мөнхбаясгалан	Хяналт, зохицуулалтын газрын захирал
	Т.Хаш-Эрдэнэ	Бизнес хөгжлийн газрын захирал
	С.Ариунсанаа	УУБАБГ-ын захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Хаяг:	Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай-3	
Үйл ажиллагаа:	Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллага	
	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх	
Ажиллагсдын тоо:	70	
Аудитор:	"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний итгэмжлэгдсэн байгууллага	



“ГРАНД ТОРНТОН АУДИТ” ХХК-Д

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИ

Сүхбаатарын талбай 3, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 31 05 01, 31 37 47, Факс: (976) 32 51 70,
Цахим шуудан: info@mse.mn, Цахим хуудас: www.mse.mn

2025.04.16 № 01/271
танай _____-ны № _____-т

Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дарга Д.Тогтохбаяр, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн болон Санхүүгийн газрын захирал Х.Эрдэнэбүрэн бид энэхүү тайлангийн 7 дугаар хуудаснаас 45 дугаар хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Д.Тогтохбаяр
ТУЗ-ийн дарга



Б.Дөлгөөн
Гүйцэтгэх захирлын
үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Х.Эрдэнэбүрэн
Санхүүгийн газрын
захирал

Огноо: 2025.04.16

Огноо: 2025.04.16.

Огноо: 2025.04.16.

1525050497

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар
ЮНЭСКО-ийн гудамж-31
Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар
14230, Монгол Улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

Монголын хөрөнгийн бирж ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:**Дүгнэлт**

Бид Монголын Хөрөнгийн Бирж ХК (цаашид "компани" эсвэл "байгууллага" эсвэл "МХБ" гэх) -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангууд (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл болон бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс баталж гаргадаг Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Олон Улсын Ёс Зүйн Дүрмийг (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандартыг багтаасан) баримтлан, нийтийн сонирхол бүхий аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитад хамаарах Монгол улсын ёс зүйн шаардлагуудын дагуу тус аж ахуйн нэгжээс хараат бус байж, эдгээр ёс зүйн шаардлагууд болон НБЁЗОУСЗ-ийн дүрэмд нийцүүлэн ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Аудитын аргачлалын хураангуй

Материаллаг байдал	- Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 2,392,368 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт татварын өмнөх ашгийн 7%-иар тооцсон. - Компани нь зээл болон нарийн төвөгтэй тооцоолол байхгүй хэдий ч өмнөх аудитаар хязгаарлалттай дүгнэлт авсан тул дээд хувь хэмжээ болох 10%-г бууруулан 7% болгон материаллаг дүнг тооцов.
--------------------	--

Бусад асуудал

Ихмонгол Хөлөг Аудит ХХК нь Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1 болон Төсвийн тухай хуулийн 8.9.8-р заалтуудад үндэслэн Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу Монголын хөрөнгийн бирж ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийж, хязгаарлалттай дүгнэлт илэрхийлсэн байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхыг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор компани доторх бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай зохистой нотолгоо олж авдаг. Бид компанийн аудитыг чиглүүлэх, хянах, гүйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтдээ хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон Гэрээт ажлын партнер нь Б.Дэлгэрмаа болно.



Огноо:


Б.ДЭЛГЭРМАА
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

Огноо: 2025. 04. 16

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	7	816,117,554	902,582,815
Дансны болон бусад авлага	8	3,119,541	2,019,384
Бараа материал		47,312	36,054
Урьдчилж төлсөн зардал		30,693	204,643
Эргэлтийн хөрөнгийн дүн		819,315,100	904,842,896
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө, цэвэр	9	7,328,148	5,453,062
Биет бус хөрөнгө, цэвэр	10	17,044,541	16,998,953
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		24,372,689	22,452,015
Нийт хөрөнгө		843,687,789	927,294,911
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	11	333,534	607,737
Урьдчилж орсон орлого	12	109,442	17,956
Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дэнчингийн өглөг	13	767,771,157	880,962,845
Богино хугацаат өр төлбөрийн дүн		768,214,133	881,588,538

Санхүүгийн байдлын тайлан

(үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Урт хугацаат өр төлбөр			
Биржийн эрсдэлийн сан	14	1,322,394	635,863
Хойшлогдсон татварын өр	15	928,380	990,699
Урт хугацаат өр төлбөрийн дүн		928,380	990,699
Өр төлбөрийн нийт дүн		769,142,513	882,579,237
Эздийн өмч			
Хувийн өмч	16.1	35,046,354	35,046,354
Дахин үнэлгээний нэмэгдэл	16.2	20,005,436	20,021,146
Эздийн өмчийн бусад хэсэг	16.3	446,322	446,322
Хуримтлагдсан ашиг	16.4	17,724,770	(11,434,011)
Эздийн өмчийн дүн		74,545,276	44,715,674
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		843,687,789	927,294,911

Хуудас 13 - 40-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Уг санхүүгийн байдлын тайланг 2025 оны 4 дүгээр сарын 16-ний өдөр батлав:



Д.Тогтохбаяр
ТУЗ-ийн дарга

Огноо: 2025.04.16



Б.Дөлгөөн
Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Огноо: 2025.07.16



Х.Эрдэнэбүрэн
Санхүүгийн газрын захирал

Огноо: 2025.04.16



Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 он	2023 он
Үйлчилгээний орлого	17	13,521,664	12,147,031
Үйлчилгээний өртөг	18	(5,166,647)	(3,943,632)
Нийт ашиг		8,355,017	8,203,399
Хүүгийн орлого	19	33,116,453	4,562,440
Бусад орлого	20	23,650	13,171
Борлуулалт, маркетингийн зардал	21	(671,208)	(399,712)
Ерөнхий ба удирдлагын зардал	22	(2,624,905)	(1,835,317)
Бусад зардал	20	(123,399)	(19,748)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	23	(99,547)	(186,717)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	24	(197)	-
Татвар төлөхийн өмнөх ашиг		37,975,864	10,337,516
Орлогын татварын зардал	25	(3,799,182)	(1,029,800)
Татварын дараах ашиг		34,176,682	9,307,716
Бусад дэлгэрэнгүй орлого (зардал)			
Дараа үед ашиг, алдагдалд дахин ангилах зүйлс	15.2	2,135	-
Бусад дэлгэрэнгүй орлого (зардал)-ын дүн		2,135	-
Орлогын нийт дүн		34,178,817	9,307,716
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (төгрөгөөр)	26	97.5	26.6

Хуудас 13 - 40-д харуулсан тодруулгууд нь энэхүү орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриятлагдсан ашиг	Биржийн эрсдэлийн сан	Нийт өмч
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл							
		23,130,594	20,021,146	446,322	(20,105,864)	-	23,492,198
Тайлант үеийн цэвэр ашиг	16.4	-	-	-	9,307,716	-	9,307,716
Өмчид гарсан өөрчлөлт	16.1	11,915,760	-	-	-	-	11,915,760
Биржийн эрсдэлийн сангийн нэмэгдэл	14	-	-	-	(635,863)	635,863	-
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл							
		35,046,354	20,021,146	446,322	(11,434,011)	635,863	44,715,674
Тайлант үеийн цэвэр ашиг	16.4	-	-	-	34,176,682	-	34,176,682
Зарласан ногдол ашиг	16.5	-	-	-	(4,349,253)	-	(4,349,253)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	16.2	-	(17,845)	-	17,845	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	16.2	-	2,135	-	-	-	2,135
Биржийн эрсдэлийн сангийн нэмэгдэл	14	-	-	-	(686,531)	686,531	-
Нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга		-	-	-	38	-	38
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл							
		35,046,354	20,005,436	446,322	17,724,770	1,322,394	74,545,276

Хуудас 13 - 40-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 он	2023 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		2,326,735,166	1,441,824,632
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17	14,891,426	11,595,182
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	20	14,356	6,128
Хүлээн авсан хүүгийн орлого	19	31,119,193	4,413,827
Хүлээн авсан дэнчин	13	2,280,703,732	1,425,607,689
Бусад мөнгөн орлого		6,459	201,806
Мөнгөн зарлагын дүн		2,410,500,738	544,905,224
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	22	-	238,000
Ажиллагчдад төлсөн	18, 21, 22	2,914,157	1,778,266
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	18, 21, 22	826,172	512,422
Бараа материал худалдан авахад төлсөн	18, 21, 22	63,965	41,110
Ашиглалтын зардалд төлсөн	18, 21, 22	85,682	111,523
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэглүүрт төлсөн	18, 21, 22	992	1,758
Татварын байгууллагад төлсөн	25	5,486,590	2,058,143
Даатгалын төлбөрт төлсөн	20	5,107	5,000
Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжинд төлсөн	18	806,791	566,128
Буцаан олгосон дэнчин	13	2,394,090,698	537,399,753
Тараасан ногдол ашиг	16.5	4,273,650	
Бусад мөнгөн зарлага		1,946,934	2,193,121
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(83,765,572)	896,919,408
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		4,500	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	24	4,500	-
Мөнгөн зарлагын дүн		3,165,765	575,344
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9	2,343,658	347,651
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10	822,107	227,693
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(3,161,265)	(575,344)

Мөнгөн гүйлгээний тайлан

(үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2024 он	2023 он
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн		-	11,915,760
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	16.1	-	11,915,760
Мөнгөн зарлагын дүн		-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-	11,915,760
Валютын ханшийн зөрүүний олз	23	461,576	(7,408,719)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		(86,465,261)	900,851,105
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7	902,582,815	1,731,710
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7	816,117,554	902,582,815

Хуудас 13 - 40-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Санхүүгийн тайлангийн тодруулгууд

1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

Монголын хөрөнгийн бирж ХК нь 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 22 тоот тогтоолоор Монгол Улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан.

Компанийн 66 хувийг Сангийн яам эзэмшдэг бөгөөд үлдсэн 34 хувийг олон нийт эзэмшдэг.

Компанийн үйл ажиллагаа нь үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх болон уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг тогтвортой, ил тод явуулах зорилготой төлбөр тооцооны өөрийгөө зохицуулах байгууллага юм.

Компани нь байгуулагдсан цагаасаа эхлэн үнэт цаасны арилжааны биржийн үйл ажиллагаа эрхэлсэн. Өмнөх онд нүүрс болон төмрийн уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалж эхэлсэн бөгөөд 2024 онд бизнесээ өргөжүүлж, жонш болон зэсийн бүтээгдэхүүнийг арилжаалж эхэлсэн байна.

2. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэсэн.

Эдгээр санхүүгийн тайланг компани нь тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулж, өр төлбөрөө цаг тухайд нь төлөх чадамжтай гэсэн таамаглалд үндэслэн бэлтгэсэн болно.

2024 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангууд түүний тодруулгуудыг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр байгууллагын удирдлага баталсан. **Тодруулга 34-с** харна уу.

Тасралтгүй үйл ажиллагаа

НББОУС 1-д заасны дагуу удирдлага нь тайлант хугацаанаас хойш багадаа 12 сарын ирээдүйн хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад эргэлзээ төрүүлэх асуудлууд байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Ийнхүү үнэлэхдээ одоогийн болон хүлээгдэж буй ашигт ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, боломжит санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадавх зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Тасралтгүй үйл ажиллагааны суурийг зохистой хэрэглэснийг баталгаажуулахын тулд компани дараах хүчин зүйлсийг авч үзсэн.

- Компани нь тайлант жилд 34,176,682 мянган төгрөг (2023: 9,307,716)-ийн ашгийг тайлагнаж, эргэлтийн хөрөнгө нь богино хугацаат өрөөс 51,100,967 мянган төгрөг (2023: 23,254,358) -өөр давсан.
- Компани нь тайлант хугацаанд 813,600 мянган төгрөг (2023: 847,916)-ийн үйл ажиллагааны эерэг мөнгөн урсгалыг бий болгосон.
- Тодруулга 28.4-д дурдсан хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг авч хэрэгжүүлдэг.

Дээрх хүчин зүйлсийг үндэслэн удирдлага нь урьдчилан харж болох ирээдүйд компанийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд хангалттай нөөцтэй гэж үзсэн.

3. Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд

3.1. 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд

2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх мэдэгдлүүд байгаа бөгөөд тэдгээр нь Компанийн санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдалд томоохон нөлөө үзүүлэхээргүй байна.

2024 онд анх удаа хүчин төгөлдөр мөрдөгдөж буй (2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болох аж ахуйн нэгжийн хувьд) болон компанид хэрэглэж болох бусад стандарт, нэмэлт өөрчлөлтүүд нь:

- Өр төлбөрийг богино болон урт гэж ангилах (НББОУС 1-ийн нэмэлт, өөрчлөлт)
- Борлуулаад буцаан түрээсэлсэн хөрөнгийн түрээсийн өр төлбөр (СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлт)
- Нийлүүлэгчийн санхүүжилтийн зохицуулалт (НББОУС 7 ба СТОУС 7-д нэмэлт, өөрчлөлт оруулах)
- Гэрээгээр хүлээсэн үүрэгтэй урт хугацаат өр төлбөр (НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт)

Эдгээр нэмэлт өөрчлөлт нь хэрэгжиж эхэлсэн эхний хугацаанд санхүүгийн тайланд томоохон нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байгаа тул тодруулгыг тусгаагүй.

3.2. Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй бусад стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлтүүд:

- Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө (НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлт)
- Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон хэмжилтийн нэмэлт өөрчлөлт (СТОУС 9 болон 7-ийн нэмэлт өөрчлөлт)
- СТОУС 18 "Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга"
- СТОУС 19 "Олон нийтийн хариуцлага хүлээгээгүй охин компаниуд: тодруулга"

Эдгээр нэмэлт өөрчлөлт нь хэрэгжиж эхэлсэн эхний хугацаанд санхүүгийн тайланд томоохон нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэж байгаа тул тодруулгыг тусгаагүй.

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй НББОУС3-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба Байгууллага нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Байгууллагын удирдлага тухайн өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар мөрдөж эхлэхээр төлөвлөж байна. Тайлант онд дагаж мөрдөх шаардлагагүй тухайн өөрчлөлтүүдийг тодруулаагүй ба тэдгээр нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй.

4. Материаллаг нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

4.1. Бүртгэлийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг аккрузль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

4.2. Гадаад валют хөрвүүлэлт

Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Санхүүгийн тайлангууд нь Монгол төгрөгөөр илэрхийлэгддэг.

Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3,420.25 төгрөг (2023 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 3,410.69 төгрөг) байна.

Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана. Тийм мөнгөн бус зүйлсийн хувьд олз, гарзын аливаа ханшийн зөрүүний хэсгийг шууд өмчид хүлээн зөвшөөрнө.

4.3. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол компани нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны төлбөр тооцооны журам"-н дагуу худалдан авагчийн дэнчинг арилжааны банканд тусгайлсан нээсэн дансанд хүлээн авч мөнгөн хөрөнгө болон уул уурхайн бүтээгдэхүүн (УУБ)-ний арилжааны дэнчингийн өглөгөөр бүртгэнэ. Арилжаанд шалгарсан худалдан авагчийн дэнчинг арилжааны гэрээний үүргийг бүрэн гүйцэтгэж дуусах хүртэл хугацаанд битүүмжилж, гэрээний үүрэг бүрэн гүйцэтгэж дууссаныг баталсан баримт бичиг ирүүлсний дараа Бирж нь дэнчинг худалдагч руу шилжүүлэн бүртгэнэ.

4.4. Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөнд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт

Санхүүгийн хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй дансны авлага болон СТОУС 15-ын дагуу ажил гүйлгээний үнээр бүртгэхээс бусад бүх санхүүгийн хөрөнгийг ажил гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хорогдуулсан өртөг
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)

Тайлант онд компанийн хувьд БҮЦБДО-оор ангилагдах санхүүгийн хөрөнгө байхгүй байна. Ангиллыг тодорхойлохдоо:

- Санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанарыг тус тус харгалзан үзнэ.

Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого болон зардал нь санхүүгийн зардал, санхүүгийн олз болон бусад санхүүгийн зүйлсээр орлого болон зардалд хүлээн зөвшөөрөгдөх ба харин дансны авлагын үнэ цэнийн бууралтыг бусад зардлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт

Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ (БУЦАА-аар ангилагдаагүй үед):

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр хэмжинэ. Хүүг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Анхны үнэ цэнийн бууралтын хасагдуулаг болон дараа үеийн өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БУЦАА)

Хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх ангиллын шаардлагад нийцэхгүй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэнэ.

Мөн тодорхой тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэхээр тогтож болно. Тухайлбал компани дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх сонголт хийж болно.

Ийм сонголтыг зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд хийнэ.

Дээрх сонголтыг бүх ижил төстэй ажил гүйлгээнд мөрдөх шаардлагагүй. Харин энэ нь илүү мэдээлэл бий болгож байгаа тохиолдолд сонгож болох хувилбар юм.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БУЦБДО)

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлнэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

4.5. Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Бараа материалын өртөг эхэлж авснаа эхэлж зарлагдах зарчимд суурилдаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардал багтана.

4.6. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулан урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зардлуудыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

4.7. Үндсэн хөрөнгө

Компани нь хөрөнгийг ашиглалтын байршилд авч ирэхэд гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан худалдан авсан өртөг эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр анхлан бүртгэнэ.

Ажил үйлчилгээний зорилгоор ашиглаж буй барилга, байгууламж, тээврийн хэрэгсэл, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дахин үнэлсэн дүн буюу дахин үнэлгээ хийсэн өдрөөрх дүнгээс дараа үеийн хуримтлагдсан элэгдсэн болон дараа үеийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхэлнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Үндсэн хөрөнгийн ангилал	Санхүүгийн зорилгоорх ашиглах жил	Татварын хуулийн зорилгоорх ашиглах жил
Барилга, байгууламж	- 60 жил	- 25 жил
Тээврийн хэрэгсэл	- 2-10 жил	- 10 жил
Тавилга, эд хогшил	- 2-10 жил	- 10 жил
Тоног төхөөрөмж	- 5-10 жил	- 10 жил

4.8. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөнд газар эзэмших эрх, программ хангамж, лиценз, мэдээллийн сан зэрэг хөрөнгүүд хамаарна.

Биет бус хөрөнгийн өртгийг худалдан авсан өртгөөр нь, дотооддоо бий болгосон бол дараах зардлын дүнг хуримтлуулан тооцох түүнийг удирдлагын хуралд оруулж танилцуулан шийдвэрлэдэг.

- Боловсруулалтын үйл ажиллагаанд оролцсон боловсон хүчинтэй холбоотой цалин хөлс бусад зардлууд
- Биет бус хөрөнгийг бий болгоход ашиглагдсан материал ба үйлчилгээний хөлс
- Биет бус хөрөнгийг бий болгоход нөлөөлсөн бусад зардлууд

Дараа үеийн хэмжилт

Ашиглах хугацаа нь тодорхой дотооддоо хөгжүүлэн капиталжуулсан программ хангамж, тусгай зөвшөөрөл зэрэг биет бус хөрөнгүүдийг өртгийн аргаар бүртгэх ба ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна. Үлдэх өртөг болон ашиглах хугацааг тайлант жил бүр дахин тооцно. Мөн үнэ цэнийн бууралтын тест хийнэ. Биет бус хөрөнгүүдийн ашиглах хугацаа нь:

Программ хангамж - 1-10 жил

Биет бус хөрөнгийг борлуулснаас үүсэх олз гарзыг борлуулалтын үнэ болон дансны үнийн зөрүүгээр хүлээн зөвшөөрч, бусад орлого болон зардлын дансанд ашиг болон алдагдлаар бүртгэнэ.

4.9. Өмч, нөөц, ногдол ашгийн төлбөр

Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Халаасны хувьцаа нь компани гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах үед худалдан авсан хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна.

Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орно. Хувьцаа гаргахтай холбоотой аливаа ажил гүйлгээний зардлыг холбогдох татвар суутгасан цэвэр дүнгээр нэмж төлөгдсөн капиталаас хасна.

Өмчийн бусад хэсэгт дараах зүйлс багтдаг. Үүнд:

- Дахин үнэлгээний нөөц нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний олз, гарзаас бүрдэнэ. **Тодруулга 16.2-с** харна уу.
- Хуримтлагдсан ашигт тайлант болон өмнөх хугацааны бүх ашиг багтана. **Тодруулга 16.4-с** харна уу.

Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө. **Тодруулга 16.5-с** харна уу.

Компани нь биржийн эрсдэлийн санг өөрийн хөрөнгийн 3 хувиас доошгүй хэмжээгээр байгуулан арилжааны банканд тусгайлан нээсэн дансанд байршуулдаг. **Тодруулга 14-с** харна уу.

4.10. Орлого хүлээн зөвшөөрөлт

Компани нь орлогыг үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх болон уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаанаас олдог. Үүнд:

1. Үнэт цаасны арилжааны шимтгэлийн орлого
2. Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэлийн орлого
3. Бүртгэлтэй компанид үзүүлсэн үйлчилгээний орлого
4. Гишүүн компанид үзүүлсэн үйлчилгээний орлого
5. Бусад үйлчилгээний орлого

Үнэт цаасны болон уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэлийн орлогын хувь хэмжээг төлөөлөн удирдах зөвлөл батлах бөгөөд хүргэх цэгт буюу хугацааны тодорхой агшинд бүртгэдэг.

Бүртгэлтэй болон гишүүн компанид үзүүлсэн үйлчилгээний орлого, бусад үйлчилгээний орлого хүлээн зөвшөөрөхдөө компани нь СТОУС 15 "Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого" -ын дагуу дараах таван алхмыг мөрддөг. Үүнд:

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээний үүрэг хариуцлагын биелэлтийг тодорхойлох
3. Арилжааны үнийг тодорхойлох
4. Арилжааны үнийг гэрээний гүйцэтгэх үүргүүдэд хуваарилах
5. Аж ахуйн нэгж гүйцэтгэх үүргээ биелүүлсэн үедээ орлогыг хүлээн зөвшөөрөх

Компани нь ажил үйлчилгээтэйгээ холбоотойгоор олон төрлийн ажил гүйлгээ хийдэг. Иймд гэрээний нийт үнийн дүн нь үүрэг хариуцлагын төрөл бүрд тус тусын үнийн дүнд харгалзуулан хуваарилагддаг. Гэрээний үнийн дүнд гуравдагч этгээдэд олгох төлбөрийг хамруулахгүй.

Орлогыг тохиролцсон ажил үйлчилгээг үзүүлэх гэрээний үүргээ биелүүлсэн бол тухайн мөчид эсвэл тодорхой хугацааны явцад хүлээн зөвшөөрнө.

Хэрэгжээгүй үүрэгт хамаарах орлого орох үед гэрээний өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх ба санхүүгийн байдлын тайланд бусад өр төлбөрөөр харуулна. Үүнтэй адилаар төлбөр ирэхээс өмнө тохиролцсон үүргийг биелүүлэх үед гэрээний хөрөнгө эсвэл авлагаар санхүүгийн байдлын тайланд тусгана.

4.11. Өртөг, зардал

Үйлчилгээний өртгийг борлуулалтын орлоготой нь уялдуулж санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна. Компани нь газар, нэгж тус бүрд ажилчдын тоо хэмжээгээр хувьчлан өртгийн төв байгуулан ангилдаг. Өртөгт Үйл ажиллагааны газар, Хяналт зохицуулалтын газар, Уул уурхайн арилжаа, бүртгэлийн газрын цалин, элэгдэл, ашиглалтын зардлууд хамаарна. Борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал, бусад зардлыг нийт дүнгээр нь толилуулна.

4.12. Нөөц, болзошгүй хөрөнгө, өр төлбөр

Шүүхийн маргаан, алдагдалтай гэрээ, зэрэг бусад төлбөрийг үүрэг өнгөрсөн үйл явдлыг үр дүнд бий болж, уг үүрэг хариуцлагыг барагдуулахад эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал шаардагдах магадлалтай бөгөөд мөнгөн дүнг найдвартай хэмжих боломжтой болсон үед нөөцөөр зөвшөөрнө.

Нөөцийг тайлангийн өдрөөр мэдэгдэж буй хамгийн найдвартай нотолгоонд үндэслэсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах зардлын мэдээлэлд суурилан тооцно. Хэд хэдэн ижил

төстэй үүрэг үүссэн үед, үүрэг хариуцлагын төрлөөр нь тэдгээрийг барагдуулахад шаардлагатай гарах урсгалын магадлалыг тооцдог. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөө үзүүлэхүйц бол нөөцийн өнөөгийн үнэ цэнийг дискаунтчлан тооцдог.

Компанийн гуравдагч талаас авах нь тодорхой болсон нөхөн олговрыг тусад нь хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Тус дүн нь холбогдох нөөцийн дүнгээс ихгүй байна.

Тухайн үүргийг барагдуулахтай холбоотой эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь магадлалтай биш үед өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй. Эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь бага дүнтэйгээс бусад үүссэн нөхцөлийг болзошгүй өр төлбөрөөр санхүүгийн тайланд тодруулна.

4.13. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцоололд ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг ерөнхийдөө түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Ийм хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт эсвэл ажил гүйлгээн дэх бусад хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь татвар ногдох орлого ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нөлөөлөхгүй байвал хүлээн зөвшөөрөхгүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацаа бүрийн эцэст эргэж харах ба хангалттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

4.14. Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тооцооллын тодорхойгүй байдалд удирдлагын шүүн тунгаалтыг ашиглах нь

Компанийн удирдлага санхүүгийн тайлан бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардал хүлээн зөвшөөрөхтэй холбоотой шүүн тунгаалт, тооцоолол, таамаглал ашигладаг.

Удирдлагын томоохон тооцоолол, таамаглал

Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо баримтлахад үүсдэг санхүүгийн тайланд томоохон нөлөөлөл үзүүлэхүйц удирдлагын тооцоолол, таамаглалыг доор харуулав. Үүнд:

Дотооддоо хөгжүүлсэн программ хангамжийг капиталжуулах

Программ бүтээхтэй холбоотой судалгаа болон хөгжүүлэлтийн үе шатыг ялган, хөгжүүлэлтийн зардлыг капиталжуулах шаардлага хангагдсан эсэхийг тодорхойлоход удирдлагын шүүн тунгаалт ашигладаг. компанийн удирдлага капиталжуулалтын дараа үнэ цэнийн бууралт хийх нөхцөл үүссэн эсэх, мөн капиталжуулалтын шаардлага хангагдсаар байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөлт

Хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхдөө шилжүүлсэн татварын алданги болон хасагдах түр зөрүү нь ирээдүйн татвар ногдох орлогоор нөхөгдөх магадлалын үнэлгээнд үндэслэнэ. Мөн татварын орчин дахь хууль эрх зүйн болон эдийн засгийн хязгаарлалт, тодорхойгүй байдлын нөлөөллийг үнэлж дүгнэдэг.

Тооцооллын тодорхойгүй байдал

Хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх, хэмжихэд хамгийн их нөлөө үзүүлэх тооцоолол, таамаглалын талаарх мэдээллийг доор харуулав.

Элэгдэх хөрөнгийн ашиглагдах жил

Удирдлага нь элэгдэх хөрөнгөнд ашиглагдах жилийг хөрөнгийн ашиглалттай уялдуулан тайлант хугацаа бүрд тооцдог. Компьютер дагалдах хэрэглүүртэй холбоотой үүсэж болзошгүй технологийн хоцрогдол нь тус тооцооллыг тодорхойгүй болгож болно.

Бодит үнэ цэнийн хэмжилт

Удирдлага нь санхүүгийн хэрэглүүр болон санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлгээний арга ашигладаг. Зах зээлд оролцогчид уг хэрэглүүрийг хэрхэн үнэлж байгаатай уялдаатайгаар тооцоо, таамаглалыг боловсруулдаг. Удирдлага нь таамаглалыг байнга нээлттэй байдаггүй боломжит мэдээллүүдэд үндэслэдэг. Тооцоолсон бодит үнэ цэнэ нь тайлагналын өдрөөрх холбоогүй талуудын гүйлгээний бодит үнээс өөр байх магадлалтай.

5. Санхүүгийн тайлангийн дахин тайлагнал

Компани алдаа илрүүлсний дараа нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт болон өмнөх үеийн алдааны залруулгыг анх баталсан санхүүгийн тайланд буцаж хэрэгжүүлдэг ба ингэхдээ алдаа гарсан өмнөх хугацаанд толилуулсан харьцуулагдах дүнг дахин тайлагнах, эсвэл толилуулсан хамгийн эхний хугацаанаас өмнө алдаа гарсан бол уг толилуулсан хамгийн эхний хугацааны хөрөнгө, өр төлбөр ба өмчийг дахин тайлагнадаг. Санхүүгийн тайланг өмнөх хугацааны харьцуулагдсан мэдээллийн хамт залруулга хийх шаардлага гарсан хугацаандаа хийгдсэн мэтээр толилуулна. Тийм учраас толилуулсан хугацаа бүрд холбогдох залруулгын дүн нь тухайн хугацааны санхүүгийн тайланд багтана.

Тайлант хугацаанд өмнөх хугацааны харьцуулагдсан мэдээллийг хамтад залруулга хийх шаардлага үүсээгүй болно.

6. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр

6.1. Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн ангилал

Тодруулга 4.4 -д санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн ангилал бүрийн тайлбар, холбогдох бүртгэлийн бодлогыг тодруулсан. Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр нь ангилал тус бүрээр дараах байдалтай байна:

2024 оны 12 сарын 31-ний байдлаар

Мянган төгрөгөөр	Хорогдуулсан өртөг	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө		Нийт
Санхүүгийн хөрөнгө					
Дансны болон бусад авлага *	3,085,468	-	-		3,085,468
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	816,117,554	-	-		816,117,554
Санхүүгийн хөрөнгийн дүн	819,203,022	-	-		819,203,022
Санхүүгийн өр төлбөр					
Дансны болон бусад өглөг *	97,549	-	-		97,549
Санхүүгийн өр төлбөрийн дүн	97,549	-	-		97,549

* Дансны болон бусад авлага, өглөгт зөвхөн санхүүгийн хөрөнгийг толилуулсан.

2023 оны 12 сарын 31-ний байдлаар

		Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх	
Мянган төгрөгөөр	Хорогдуулсан өртөг		санхүүгийн хөрөнгө	Нийт
Санхүүгийн хөрөнгө				
Дансны болон бусад авлага	2,017,926	-	-	2,017,926
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	902,582,815	-	-	902,582,815
Санхүүгийн хөрөнгийн дүн	904,600,741	-	-	904,600,741
Санхүүгийн өр төлбөр				
Дансны болон бусад өглөг	266,433	-	-	266,433
Санхүүгийн өр төлбөрийн дүн	266,433	-	-	266,433

Компанийн эрсдэлийн удирдлагын зорилго, бодлого зэрэг санхүүгийн хэрэглүүрийн эрсдэлийн тодруулгыг тодруулга 28-с харна уу.

7. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Бэлэн мөнгө	1,422	15
Банкин дахь харилцах дансны үлдэгдэл		
- Төгрөг	80,769	364,900
- Ам.доллар*	695,912,333	811,253,331
- Юань*	75,236,809	84,628,706
Хугацаатай хадгаламж (3-12 сар хүртэлх)*	44,886,221	6,335,863
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	816,117,554	902,582,815

* Валютаарх мөнгөн хөрөнгө

Валютаар	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Ам.доллар	203,468,265	237,856,073
Юань	160,566,850	176,306,130

* Хугацаатай хадгаламж

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний байдлаар				
	Валют	Эхэлсэн огноо	Дуусах огноо	Хүүгийн хувь (жилийн)	Мөнгөн дүн
Банк 1	Ам.доллар	2024.10.07	2025.01.06	4.3%	5,603,209
Банк 2	төгрөг	2024.11.01	2025.02.02	12.9%	7,501,700
Банк 2	төгрөг	2024.11.07	2025.02.07	12.9%	2,000,000
Банк 1	төгрөг	2024.07.05	2025.07.04	16.1%	4,500,000
Банк 1	төгрөг	2024.09.12	2025.09.12	16.1%	8,500,000
Банк 1	төгрөг	2024.10.07	2025.10.06	16.1%	2,215,050
Банк 1	төгрөг	2024.12.10	2025.12.09	16.1%	2,500,000
Банк 3	төгрөг	2024.07.01	2025.07.01	14.9%	635,862
Банк 4	төгрөг	2024.05.10	2025.05.10	16.1%	11,430,400
Арилжааны банканд байршуулсан хугацаатай хадгаламж (3-12 сар)*					44,886,221

Мянган төгрөгөөр	2023 оны 12 сарын 31-ний байдлаар				
	Валют	Эхэлсэн огноо	Дуусах огноо	Хүүгийн хувь (жилийн)	Мөнгөн дүн
Банк 1	төгрөг	2023.10.23	2024.01.23	13.3%	5,700,000
Банк 2	төгрөг	2023.06.27	2024.06.27	13.0%	635,863
Арилжааны банканд байршуулсан хугацаатай хадгаламж (3-12 сар)*					6,335,863

Ам.долларын болон төгрөгийн 3-12 сарын хугацаатай хадгаламжууд байна. Эдгээр хадгаламжуудыг дуусгавар болох хугацаанаас нь өмнө зарлагын гүйлгээ хийсэн, хугацаанаас нь өмнө хадгаламжийн гэрээг цуцлах тохиолдолд ам.долларын хадгаламжийн жилийн хүү 0.5%-иар, төгрөгийн хадгаламжийн жилийн хүү 2.0-2.4% болж буурах нөхцөлтэй байна.

Арилжааны банкууд дахь ам.доллар болон юанийн харилцах дансны үлдэгдэл 767,771,157 төгрөг нь уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаанд оролцогчдын байршуулсан дэнчингийн нийт үлдэгдэл болно. Үүнд арилжаанд оролцогчдын ялсан арилжааны битүүмжлэгдсэн дэнчин болон арилжаанд оролцохоор идэвхтэй байгаа дэнчингийн үлдэгдлийг бүртгэсэн байна.

8. Дансны болон бусад авлага

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Арилжааны шимтгэлийн авлага	424,981	1,359,778
Биржид бүртгэлтэй компанийн жилийн үйлчилгээний авлага	486,008	510,271
Бусад үйлчилгээний авлага	235,073	230,753
Найдваргүй дансны авлагын хасагдуулга	(209,129)	(232,347)
Цэвэр дансны авлага	936,933	1,868,455
Банкны хүүгийн авлага	2,148,535	148,590
Бусад авлага	-	881
Санхүүгийн хөрөнгийн дүн	3,085,468	2,017,926
Татварын авлага	34,022	1,436
Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	51	22
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	34,073	1,458
Дансны болон бусад авлагын дүн	3,119,541	2,019,384

Үйлчилгээний авлага цуглуулах дундаж хугацаа нь 25 хоног (2023: [56] хоног) байна.

Дансны авлагад хүү тооцохгүй. Компани авлага цугларах боломжгүй нь тодорхой болсон үед шууд аргыг хэрэглэн бүрэн нөөц байгуулдаг. Ингэхдээ найдваргүй авлагын нөөц байгуулах талаарх ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн байгуулдаг. Дансны авлагыг өнгөрсөн үеийн туршлагаар тодорхойлж, бараа үйлчилгээний борлуулалтаас тооцсон нөхөгдөөгүй дүнд үндэслэн гаргасан.

Найдваргүй авлагын зардлыг бүртгэхдээ авлага цугларах боломжгүй нь тодорхой болсон үед шууд аргыг хэрэглэдэг. Энэ арга нь үл цуглуулагдах хэмжээгээр шууд хөрөнгийн данснаас зардлын дансанд шилждэг. Найдваргүй авлагын хэмжээг тодорхойлж, шийдвэрлэх хүртэл бүртгэлд тусгахгүй.

Дансны авлагыг төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн, төлөгдөх найдваргүй гэж ангилна. Дансны авлагын насжилтын ангилал болон найдваргүй авлагын хасагдуулаг байгуулсан аргыг тодруулга 28.3-с харна уу.

Авлага болон бусад авлагыг илэрхийлсэн валютыг тодруулга 28.2-аас харна уу.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд

2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

9. Үндсэн хөрөнгө

Мянган төгрөгөөр	Барилга, байгууламж	Дуусаагүй барилга	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Машин, тоног төхөөрөмж	Нийт
Өртөг							
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	4,924,999	-	36,850	121,104	258,434	403,243	5,744,630
Нэмэгдсэн	-	-	-	51,157	128,668	142,631	322,456
Хасагдсан	-	-	(29,500)	-	-	-	(29,500)
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,924,999	-	7,350	172,261	387,102	545,874	6,037,586
Хөрөнгө							
Нэмэгдсэн	-	1,671,772	161,000	13,005	112,336	310,158	2,268,271
Хасагдсан	-	-	(7,350)	(1,168)	(2,307)	(7,500)	(18,325)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	271	1,000	1,100	2,371
Үндсэн хөрөнгийн дахин ангилал	-	-	-	-	(128,668)	128,668	-
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,924,999	1,671,772	161,000	184,369	369,463	978,300	8,289,903
Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт							
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	53,441	-	30,112	19,626	14,395	90,573	208,147
Тухайн жилийн өөрчлөлт	106,881	-	1,225	40,674	43,507	213,590	405,877
Данснаас хассан	-	-	(29,500)	-	-	-	(29,500)
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	160,322	-	1,837	60,300	57,902	304,163	584,524
Тухайн жилийн өөрчлөлт	106,881	-	6,592	33,483	60,375	183,937	391,268
Данснаас хассан	-	-	(3,063)	(1,167)	(2,307)	(7,500)	(14,037)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	267,203	-	5,366	92,616	115,970	480,600	961,755
Үлдэгдэл өртөг							
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,657,796	1,671,772	155,634	91,753	253,493	497,700	7,328,148
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,764,677	-	5,513	111,961	329,200	241,711	5,453,062

Тайлант өдрөөр барьцаанд байгаа компанийн үндсэн хөрөнгө байхгүй. 2024 оны нэмэгдсэн дүн нь 2,270,642 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (2023: [322,456] мянган төгрөг) ба үндсэн хөрөнгийн 596,499 мянган төгрөгийн худалдан авалт (2023: [322,456] мянган төгрөг), дуусаагүй барилга 1,671,772 мянган төгрөгийн капиталжуулалт (2023: 0 мянган төгрөг), дахин үнэлгээний 2,371 мянган төгрөгийн нэмэгдлээс (2023: 0 мянган төгрөг) бүрдэнэ.

2024 онд дуусаагүй барилга дансанд оффисын доторх ерөөний зохион байгуулалтын өөрчлөлтөд оруулах их засварын ажилтай холбоотой гэрээний урьдчилгаа төлбөрүүд, зөвлөх үйлчилгээ, зураг төслийн төлбөрүүд болох 1,671,772 мянган төгрөгийг хуримтлуулан бүртгэсэн. Тус их засварын ажлыг хариуцаж буй Тамга-Уул ХХК-ны засварын ажил он дамнан үргэлжилж захиалагчийн хяналтын тал болох Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас гүйцэтгэлийн тайланг баталгаажуулан өгснөөр нийт гэрээний төлбөрийн 70% шилжүүлэгдсэн. Барилгын зохион байгуулалтын шинэчлэлтийн зураг төсвийн төлбөр болон серверийн ерөөний зөвлөх үйлчилгээний ажил бүрэн гүйцэт хийгдсэн ч барилгын ажил бүхэлдээ бүрэн дуусаж хүлээлгэн өгсний дараа үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулахаар хүлээгдэж байгаа тул дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэгдсэн байна.

2024 онд 2023 онд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, ашиглах боломжгүй 6,232 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгүүдийг акталж, 4,743 мянган төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн ч ашиглах боломжтой хөрөнгүүдийг 2,371 мянган төгрөгөөр дахин үнэлсэн. Мөн их хэмжээний засвар үйлчилгээ шаардлагатай, засвар үйлчилгээ хийж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон 4,287 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулсан.

Компанийн 2,371 мянган төгрөгийн тавилга эд хогшил, компьютер тоног төхөөрөмж, машин тоног төхөөрөмжийг 2024.10.04-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн 46 дугаар тогтоолоор дахин үнэлсэн. Үнэлгээг бодит үнэ цэнд үндэслэн хийсэн. Дахин үнэлгээний нэмэгдлийн цэвэр дүнд холбогдох урьдчилж орсон орлогын татварыг эздийн өмч дэх дахин үнэлгээний нөөцөд бүртгэсэн байна.

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 83 төрлийн 310.250 мянган төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа бөгөөд 2025 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр актлах, дахин үнэлэх эсэхийг шийдвэрлэнэ.

10. Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Компьютерын программ хангамж	Тусгай зөвшөөрөл	Газар эзэмших эрх	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
Өртөг					
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	7,573,724	26,720	10,567,761	-	18,168,205
Нэмэгдсэн	224,879	-	13,160	-	238,039
Хасагдсан	-	-	-	-	-
Биет бус хөрөнгийн дахин ангилал	(177,674)	(26,720)	-	204,394	-
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	7,620,929	-	10,580,921	204,394	18,406,244
Нэмэгдсэн	722,620	-	-	295,666	1,018,286
Хасагдсан	(113,567)	-	-	(125,798)	(239,365)
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	8,229,982	-	10,580,921	374,262	19,185,165

Мянган төгрөгөөр	Компьютерын программ хангамж	Тусгай зөвшөөрөл	Газар эзэмших эрх	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
Хуримтлагдсан хорогдуулга					
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	508,633	11,133	-	-	519,766
Нэмэгдсэн	884,853	2,672	-	-	887,525
Данснаас хасагдсан	-	-	-	-	-
Биет бус хөрөнгийн дахин ангилал	(147,322)	(13,805)	-	161,127	-
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,246,164	-	-	161,127	1,407,291
Нэмэгдсэн	815,352	-	-	157,346	972,698
Данснаас хасагдсан	(113,567)	-	-	(125,798)	(239,365)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,947,949	-	-	192,675	2,140,624
Үлдэгдэл өртөг					
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,282,033	-	10,580,921	181,587	17,044,541
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,374,765	-	10,580,921	43,267	16,998,953

2024 оны нэмэгдсэн дүн нь 1,018,286 мянган төгрөгийн биет бус хөрөнгө (2023: [238,039] мянган төгрөг) ба энэ нь биет бус хөрөнгийн өртөгт капиталжуулсан 689,593 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт (2023: [0] мянган төгрөг), [328,693] мянган төгрөгийн худалдан авалтаас (2023: [238,039] мянган төгрөг) бүрдэнэ. Тайлант онд 2023 онд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 239,365 мянган төгрөгийн биет бус хөрөнгүүдийг акталсан.

Программ хангамжид бүртгэлтэй Милленниум Ай Ти (MIT) системийг Монголын хөрөнгийн зах зээлд 2012 оны 07 сараас албан ёсоор нэвтрүүлсэн бөгөөд нийт зах зээлийн хэмжээнд ашиглаж байна. MIT системийн өртөг тайлант оны эцэст 7,528,825 мянган төгрөг байна. Программ хангамжид MIT системийн дагалдах Oracle мэдээллийн сангууд, уул уурхайн биржийн цахим арилжааны систем, санхүү, хүний нөөцийн программууд багтсан болно.

Газар эзэмших эрх нь оффисын барилгын доорх газар болон Сэлэнгэ аймаг дахь газар тариалангийн 2 газраас бүрдэнэ. Оффисын барилгын доорх газар нь 15 жилийн хугацаатай эзэмших 1,055 мкв бүхий худалдаа, нийтийн үйлчилгээний газрын зориулалттай. Сэлэнгэ аймаг дахь газрууд нь Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд байршилтай, үр тарианы тариалангийн зориулалттай газрууд юм. 2010 онд тус газрыг "Бүрэн-Эрдэнэ монс" ХХК-тай "Газар худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулсан боловч гэрээ хүчин төгөлдөр бус гэж үзэн газрын эрхийг өдийг хүртэл шилжүүлээгүй. 2025 онд шүүхээс тус гэрээг хүчин төгөлдөр бусад тооцож, "Бүрэн-Эрдэнэ монс" ХХК-д газрыг албадан чөлөөлөхийг даалгасан. Газар эзэмших эрхийн бодит үнэ цэнийн талаарх мэдээллийг тодруулга 30.1-с харна уу.

11. Дансны ба бусад өглөг

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Дансны өглөг (*1)	91,734	265,821
Татварын өглөг	235,985	341,304
Бусад өглөг	5,815	612
Дансны ба бусад өглөгийн дүн	333,534	607,737

Дансны өглөгт ямар нэгэн хүү тооцохгүй. Компани зээлийн хугацаанд бүх өглөгийг төлөх санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлоготой.

(*1) Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд байршилтай, газар тариалангийн зориулалттай газрыг 2010 онд "Бүрэн-Эрдэнэ монс" ХХК-тай "Газар худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулан нийт

19,760 мянган төгрөгөөр борлуулахаар тохиролцож, 2010, 2011 онуудад газрын үнийг хүлээн авсан боловч газрын эрхийг тус компанид шилжүүлээгүй өр төлбөр багтана. Компани энэхүү өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн авсан мөнгөн дүнгээр зөвшөөрч, газар эзэмших эрх дансанд капиталжуулан бүртгэсэн. 2025 онд шүүх тус гэрээг хүчин төгөлдөр бусад тооцож, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д хэлцлээр шилжүүлсэн зүйл болох 19,760 мянган төгрөгийг "Бүрэн-Эрдэнэ монс" ХХК-д олгохыг даалгасан тул компани цаашид өглөгийг шүүхийн шийдвэрийн дагуу хэрэгжүүлж данснаас хасах юм.

12. Урьдчилж орсон орлого

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Эхний үлдэгдэл	17,956	15,396
Нэмэгдсэн	140,955	351,049
Хасагдсан (орлогоор хүлээн зөвшөөрсөн)	(49,469)	(348,489)
Урьдчилж орсон орлогын дүн	109,442	17,956

13. Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дэнчингийн өглөг

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Идэвхтэй дэнчингийн өглөг	41,114,144	335,530,835
Битүүмжлэгдсэн дэнчингийн өглөг	726,657,013	545,432,010
УУБ-ний арилжааны дэнчингийн өглөгийн дүн	767,771,157	880,962,845

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дэнчингийн өглөгийн хөдөлгөөнийг доор тодруулав:

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дэнчингийн эхний үлдэгдэл	880,962,845	-
Хүлээн авсан дэнчин	2,280,703,732	1,425,607,689
Буцаан олгосон дэнчин	(2,394,090,698)	(537,399,753)
Арилжааны шимтгэлд суутган авсан	(366,225)	(20,199)
Валютын ханшийн нөлөө	561,503	(7,224,892)
Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дэнчингийн эцсийн үлдэгдэл	767,771,157	880,962,845

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023.06.26 өдрийн 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам"-ын дагуу уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцогч нь биржийн дэнчинг биржийн тусгайлан нээсэн харилцах дансанд байршуулдаг.

Арилжаанд оролцогч арилжаанд ялбал бирж нь ялагчийн дэнчинг битүүмжилж, бүтээгдэхүүн арилжаалагдан худалдагчаас худалдан авагчид хүлээлгэн өгснийг баталгаажуулсны дараа битүүмжилсэн дэнчинг худалдагчид шилжүүлдэг.

Компани УУБ-ний арилжааны дэнчинг санхүүгийн тайланд хүлээн авсан мөнгөн дүнгээр зөвшөөрч, УУБ-ний дэнчингийн өр төлбөрөөр ангилж бүртгэдэг.

14. Биржийн эрсдэлийн сан

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Эхний үлдэгдэл	635,863	-
Нэмэгдсэн	686,531	635,863
Хасагдсан (Зардлаар хүлээн зөвшөөрсөн)	-	-
Биржийн эрсдэлийн сангийн дүн	1,322,394	635,863

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны 187 дугаар тогтоол "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр тооцоо хийх ерөнхий журам"-ын дагуу Бирж нь "Спот, Форвард гэрээний арилжааны хувьд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд өөрийн хөрөнгийн 3 хувиар эрсдэлийн санг байгуулна" гэж заасны дагуу эрсдэлийн санг байгуулсан.

МХБ ХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19 өдрийн 57 дугаар тогтоолоор "Эрсдэлийн сангийн журам"-ыг батлуулсан. Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2025 оны 02 сарын 17-ны өдрийн 54 дугаар тушаалаар тус журмыг батламжилсан байна.

15. Хойшлогдсон орлогын албан татвар

Хойшлогдсон орлогын албан татварын хөдөлгөөнийг доор тодруулав:

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Эхний үлдэгдэл	990,699	990,846
Бусад дэлгэрэнгүй орлогыг (бууруулсан)/өсгөсөн	237	-
Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн	(62,556)	(147)
Эцсийн үлдэгдэл	928,380	990,699

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон хугацааны хойшлогдсон орлогын албан татвар нь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2024 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн	Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн	2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл
Хойшлогдсон татварын хөрөнгө				
Мөнгөн хөрөнгө	(484,355)	-	1,025,811	541,456
Үндсэн хөрөнгө	324,539	237	161,578	486,354
Биет бус хөрөнгө	582,274	-	(70,778)	511,496
Дансны авлага	(91)	-	148	57
Дансны өглөг	39	-	(12)	27
УУБ дэнчингийн өглөг	568,293	-	(1,179,303)	(611,010)
Цэвэр дүн – хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)	990,699	237	(62,556)	928,380

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон хугацааны хойшлогдсон орлогын албан татвар нь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2023 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн	Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн	2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл
<i>Хойшлогдсон татварын хөрөнгө</i>				
Мөнгөн хөрөнгө	-	-	(484,355)	(484,355)
Үндсэн хөрөнгө	337,794	-	(13,255)	324,539
Биет бус хөрөнгө	653,052	-	(70,778)	582,274
Дансны авлага	-	-	(91)	(91)
Дансны өглөг	-	-	39	39
УУБ-ний дэнчингийн өглөг	-	-	568,293	568,293
Цэвэр дүн – хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)	990,846	-	(147)	990,699

Бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрсөн дүн нь машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, компьютер бусад хэрэгслийн дахин үнэлгээтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн хойшлогдсон татварын өглөгийн уг өөрчлөлт нь Монгол Улсын татварын хуульд хийгдсэн өөрчлөлтөөс шалтгаалан үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн элэгдэл, хоргодуулалтын тооцооллын зарчмын томоохон өөрчлөлтөөс үүссэн байна. **Тодруулга 4.7-с харна уу.**

16. Капитал ба нөөц

16.1. Хувьцаат капитал /дүрмийн сан/

Мянган төгрөгөөр	Энгийн хувьцаа	
	2024 он	2023 он
Нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй энгийн хувьцаа (ширхэг)	350,463,539	350,463,539
Гаргасан болон бүрэн төлсөн (мянган төгрөг)	35,046,354	35,046,354
Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:	-	-
- Тайлант хугацааны эхэнд	35,046,354	35,046,354
- Тайлант хугацаанд нэмж гаргасан хувьцаа	-	-
Тайлант хугацаанд буцаан худалдаж авсан хувьцаа	-	-
Тайлант хугацааны эцэст	35,046,354	35,046,354

Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай. Компанийн хувьцааны 231,305,936 ширхэг буюу 66 хувийг Сангийн яам эзэмшдэг бол 119,157,603 ширхэг буюу 34 хувийг олон нийтэд нээлттэй арилжаалагддаг энгийн хувьцаа бүрдүүлдэг.

16.2. Дахин үнэлгээний нөөц

Мянган төгрөгөөр	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдэл	Нийт дүн
2024 оны 01 сарын 01-ний байдлаар	20,021,146	-	20,021,146
Нэмэгдсэн			
- Дахин үнэлгээний нэмэгдэл	2,371	-	2,371
- Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	(18,081)	-	(18,081)
2024 оны 12 сарын 31-ний байдлаар	20,005,436	-	20,005,436

Дахин үнэлгээний нөөц нь газар, барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, биет бус хөрөнгийн дахин үнэлгээнээс үүссэн. Дахин үнэлсэн машин тоног

төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталсан үед болон тээврийн хэрэгслийг борлуулсан үед хөрөнгийн дахин үнэлгээний нөөцийн хувь тухайн хөрөнгөөс хамаарах бөгөөд бодитоор хэрэгжүүлж хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлдэг.

16.3. Эздийн өмчийн бусад хэсэг

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Барилга (1)	432,961	432,961
Газар (2)	13,361	13,361
Эздийн өмчийн бусад хэсгийн дүн	446,322	446,322

(1) Төрийн өмчийн хорооны 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 340 дугаар тогтоолоор "Үнэт цаас төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 432,961 мянган төгрөгийн үнэ бүхий 273.71 м.кв ажлын байрны зориулалттай 3 давхрын талбайг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д балансаас баланст шилжүүлсэн байна.

(2) "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгаа 13,361 мянган төгрөгийн үнэ бүхий биржийн барилга доорх газрыг анх 2009 онд тухайн Улаанбаатар хотын газрын жишиг үнээр үнэлж эздийн өмчийн бусад хэсэгт тусгасан байна.

16.4. Хуримтлагдсан ашиг

Үйл ажиллагаа эхэлсэн үеэс нэмэгдсэн капитал. Энэ нь тухайн тайлангийн хугацаанд олсон цэвэр ашгийн хэмжээгээр нэмэгдэнэ. Тайлант жилд хүүгийн орлого өндөр өссөнтэй холбоотойгоор нийт цэвэр ашиг 3.6 дахин өссөнөөр хуримтлагдсан алдагдлаа нөхөн хуримтлагдсан ашигтай ажилласан байна.

16.5. Ногдол ашиг

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.4, 47 дугаар зүйлийн 47.1, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.17 дахь заалт, компанийн "Ногдол ашгийн бодлого"-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн 08 тогтоолоор 2023 оны жилийн эцсийн аудитлаагүй санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашгаас нэгж хувьцаанд 12 төгрөг 41 мөнгө буюу 4,349,252,518.99 төгрөгийн ногдол ашгийг зарлаж, 2024 онд хуваарилан олгосон.

17. Үйлчилгээний орлого

Үйлчилгээний орлого нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны шимтгэл болон үйлчилгээний хөлсний орлого (*1)	8,626,364	7,118,403
Үнэт цаасны арилжааны орлого (*2)	3,314,850	2,598,470
Биржид бүртгэлтэй компанид үзүүлсэн үйлчилгээний орлого	1,032,886	1,953,965
Гишүүн компанид үзүүлсэн үйлчилгээний орлого	302,700	109,282
Бусад үйлчилгээний орлого	244,864	366,911
Үйлчилгээний орлогын дүн	13,521,664	12,147,031

(*1) Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны орлого
Тайлант жилд дуудлага худалдаагаар 8,276,040.8 сая төгрөгийн хэлцлийн үнийн дүнтэй 22,368 мянган тонн нүүрс, 567,767.9 сая төгрөгийн хэлцлийн үнийн дүнтэй 2,425.5 мянган тонн төмөр, 9,982.9 сая төгрөгийн хэлцлийн үнийн дүнтэй 17.6 мянган тонн жонш, 40,500.7 сая төгрөгийн хэлцлийн үнийн дүнтэй 6 мянган тонн зэс биржээр арилжаалагдсан байна. Компани нь арилжаалагдсан бүтээгдэхүүний үнийн дүнгээс 0.08%-с 0.1%-н арилжааны шимтгэл хүлээн авдаг.

(*2) Үнэт цаасны арилжааны орлого
Анхдагч болон хоёрдогч зах зээл дээр 352,334 сая төгрөгийн арилжааны үнийн дүнтэй хувьцаа, 896,253 сая төгрөгийн арилжааны үнийн дүнтэй бонд, 146,637 сая төгрөгийн арилжааны үнийн

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

дүнтэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 10,899 сая төгрөгийн арилжааны үнийн дүнтэй хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх биржээр арилжаалагдсан байна.

Компанийн орлогыг хүлээн зөвшөөрөх онцлогоор нь задалж харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

2024 оны 12 сарын 31-ний байдлаар

Мянган төгрөгөөр	Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны орлого	Үнэт цаасны арилжааны орлого	Бүртгэлтэй компанид үзүүлсэн үйлчилгээний орлого	Гишүүн компанид үзүүлсэн үйлчилгээний орлого	Бусад үйлчилгээний орлого
Хүргэх цэгт буюу хугацааны тодорхой агшинд бүртгэсэн орлого	8,626,364	3,314,850	-	-	-
Цаг хугацааны явцад хүлээн зөвшөөрөх орлого	-	-	1,032,886	302,700	244,864
Бүгд	8,626,364	3,314,850	1,032,886	302,700	244,864

2023 оны 12 сарын 31-ний байдлаар

Мянган төгрөгөөр	Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны орлого	Үнэт цаасны арилжааны орлого	Бүртгэлтэй компанид үзүүлсэн үйлчилгээний орлого	Гишүүн компанид үзүүлсэн үйлчилгээний орлого	Бусад үйлчилгээний орлого
Хүргэх цэгт буюу хугацааны тодорхой агшинд бүртгэсэн орлого	7,118,403	2,598,470	-	-	-
Цаг хугацааны явцад хүлээн зөвшөөрөх орлого	-	-	1,953,965	109,282	366,911
Бүгд	7,118,403	2,598,470	1,953,965	109,282	366,911

18. Үйлчилгээний өртөг

Үйлчилгээний өртөг нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Ажилчдын цалингийн зардал	1,700,591	1,029,457
Зохицуулалтын үйлчилгээний хөлс *	1,138,053	704,567
MIT систем ашиглалтын зардал *	1,004,387	1,041,897
Хорогдлын зардал	923,432	886,537
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	212,583	125,897
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	100,116	88,947
Элэгдлийн зардал	21,526	24,430
Бусад зардал	65,959	41,900
Үйлчилгээний өртгийн дүн	5,166,647	3,943,632

Зохицуулалтын үйлчилгээний хөлс *
Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Зохицуулах үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-н дагуу компани нь шимтгэлийн орлогын 10 хувьтай тэнцүү үйлчилгээний хөлсийг санхүүгийн зохицуулах хороонд төлдөг.

MIT систем ашиглалтын зардал *
Компани нь арилжаа зохион байгуулахтай холбоотойгоор Лондонгийн хөрөнгийн биржийн хөгжүүлсэн Миллениум Ай Ти систем ашигладаг бөгөөд жил бүр тогтмол ашиглалтын болон техникийн үйлчилгээний төлбөр төлдөг.

19. Хүүгийн орлого

Хүүгийн орлого нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Харилцах дансны хүүгийн орлого	29,438,522	3,924,920
Хадгаламжийн дансны хүүгийн орлого	3,677,931	637,520
Хүүгийн орлогын дүн	33,116,453	4,562,440

Тайлант жилийн нийт хүүгийн орлогын 89%-ийг харилцах дансны хүүгийн орлого, 11%-ийг хадгаламж дансны хүүгийн орлого эзэлж байна. Арилжааны 4 банкны 14 төрлийн харилцах дансны үлдэгдэлд банктай хийсэн гэрээний дагуу сар бүр хүүгийн орлого тооцоологддог. Арилжааны банкнуудаас энгийн харилцах дансандаа 1 жилийн хугацаатай 0%-3%-ийн хүүтэйгээр гэрээлсэн байна.

20. Бусад орлого /зардал

Бусад орлого нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Үйл ажиллагааны бус бусад орлого	23,218	13,171
Даатгалын нөхөн төлбөр	432	-
Бусад орлогын дүн	23,650	13,171

Бусад зардал нь дараахаас бүрдэнэ:

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Нийгэм,соёлын зардал	120,480	17,428
Алданги, торгуулийн зардал	72	-
Бараа материал акталсан зардал	1,151	-
Үйл ажиллагааны бус бусад зардал	1,696	2,320
Бусад зардлын дүн	123,399	19,748

21. Борлуулалт, маркетингийн зардал

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Ажилчдын цалингийн зардал	444,395	295,831
Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	91,737	47,300
Томилолтын зардал	55,675	40,143
Ашиглалтын зардал	31,898	1,207
Харилцаа холбооны зардал	5,109	6,227
Элэгдлийн зардал	2,819	3,231
Зар сурталчилгааны зардал	425	5,252
Бусад зардал	39,150	521
Борлуулалт, маркетингийн зардлын дүн	671,208	399,712

22. Ерөнхий ба удирдлагын зардал

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Ажилчдын цалингийн зардал	1,432,746	863,124
Элэгдлийн зардал	369,317	376,195
Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	172,784	107,708
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	168,455	259,632
Томилолтын зардал	143,620	33,879
Сургалтын зардал	99,121	19,679
Хорогдлын зардал	49,267	988
Татвар, хураамжийн зардал	34,496	1,857
Ашиглалтын зардал	35,818	27,659
Хангамжийн зардал	31,368	32,475
Засварын зардал	16,577	23,510
Харилцаа холбооны зардал	11,564	11,716
Бусад зардал	59,772	76,895
Ерөнхий ба удирдлагын зардлын дүн	2,624,905	1,835,317

22.1. Ажиллагсдын цалингийн зардал

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Цалин хөлс	2,902,574	1,867,216
Байгууллагаас төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэл	441,042	273,478
Нэмэгдэл хөнгөлөлтүүд*	675,158	321,196
Ажиллагсдын цалингийн зардлын дүн	4,018,774	2,461,890

* Нэмэгдэл хөнгөлөлтүүд

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Ажлын гүйцэтгэлийн нэмэгдэл	640,087	321,196
Ажилласан жилийн нэмэгдэл	35,071	-
Нэмэгдэл хөнгөлөлтийн дүн	675,158	321,196

23. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/(гарз)		
- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	461,576	(7,408,719)
- Дансны болон бусад авлага	380	(2,890)
- Дансны болон бусад өглөг	(561,503)	7,224,892
Гадаад валютын ханшийн зөрүүний гарзын дүн	(99,547)	(186,717)

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дэнчин нь ам.доллар болон юаниар байршдаг тул мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, өглөгийн дүнд тооцсон гадаад валютын ханшийн зөрүүнээс үүссэн бодит бус гарз ихээхэн хэмжээгээр бүртгэгддэг.

24. Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз	(197)	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарзын дүн	(197)	-

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 48 дугаар тогтоолын дагуу их хэмжээний засвар үйлчилгээ шаардлагатай, засвар үйлчилгээ хийж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон [4,287] мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, үндсэн хөрөнгө борлуулсны гарз 197 мянган төгрөг бүртгэгдсэн.

25. Орлогын татварын зардал/(нөхөлт)

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Тайлант жилийн татвар	3,861,738	1,029,947
Өмнөх жилийн татвартай холбоотой тайлант жилд хүлээн зөвшөөрсөн залруулга	-	-
Хойшлогдсон татвар (тодруулга 15-с харна уу)	(62,556)	(147)
Дүн	3,799,182	1,029,800

Үр ашигт татварын хувь хэмжээний нэгтгэл нь дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу)	37,975,864	10,337,516
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцох татвар ногдох орлого	-	(47,600)
Бусдад суутгуулсан орлого	(33,116,454)	(4,562,440)
Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө/ өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөөгүй түр зөрүү	625,560	1,471
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	15,960	8,082
Нийт татвар ногдох орлого	5,500,930	5,737,029
Нийтлэг хувь хэмжээгээр ногдох орлогын албан татвар (2023: 10%, 25%)	550,093	573,703
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцох орлогын албан татвар (2023: 10%)	-	-
Бусдад суутгуулсан татвар	3,311,645	456,244
Хойшлогдсон орлогын албан татварын зардал	(62,556)	(147)
Орлогын албан татварын зардал/ (нөхөлт)	3,799,182	1,029,800

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн мэдээллийг тодруулга 15-с харна уу.

26. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Татварын дараах ашиг	34,176,682	9,307,716
Жинлэсэн дундаж хувьцааны тоо хэмжээ	350,463,539	350,463,539
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (төгрөгөөр)	97.5	26.6

Компанийн хувьцааны тоо хэмжээ 2023 болон 2024 онуудад өөрчлөгдөөгүй тул жинлэсэн дундаж хувьцааны тоо хэмжээ нь жилийн эцсийн хувьцааны тоо хэмжээтэй ижил байна.

27. Холбоотой талын ажил гүйлгээ

Компанийн холбоотой талд Монгол Улсын Засгийн газар, Сангийн Яам болон ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлага хамаарна.

27.1. Хяналтын харилцаа

Компанийн нийт хувьцааны 66%-ийг Сангийн яам эзэмшдэг бөгөөд хяналтын эрх бүхий дээд байгууллага нь Монгол Улсын Засгийн газар юм. Үлдсэн 34 хувийг олон нийт эзэмшдэг.

27.2. Хувьцаа эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацаанд компани нь дараах ажил гүйлгээг хувьцаа эзэмшигчидтэй хийсэн:

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Ногдол ашиг		
Сангийн яам	2,870,507	-

27.3. Удирдлага болон тэдний ойр дотны гэр бүлийн гишүүдтэй хийсэн ажил гүйлгээ

Голлох удирдлагад Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, тэдний гэр бүлийн гишүүд хамаарна. Голлох удирдлагын тайлант оны цалин хөлс, урамшуулал, холбогдох бусад тэтгэмжийн зардал дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Цалин	273,369	196,542
Байгууллагаас төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэл	30,546	24,196
Дүн	303,915	220,738

27.4. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний үлдэгдэл

Мянган төгрөгөөр	2024 он	2023 он
Өглөг		
- ТУЗ-ийн цалингийн өглөг	722	-
- Гүйцэтгэх захирлын цалингийн өглөг	2,139	-
Өглөгийн дүн	2,861	-

28. Болзошгүй өр төлбөр

Тайлант хугацаанд компанийн эсрэг хуулийн зарга маргаантай холбоотой болзошгүй өр төлбөр байхгүй байна

29. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл

Хүлээн зөвшөөрөх шалгуур, орлого зарлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэл, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн хэрэглүүрийн ангиллын талаар хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, арга зэргийг тодруулга 4-д дэлгэрэнгүй харуулсан болно.

Компани нь санхүүгийн хэрэглүүрийн идэвхтэй арилжаанд оролцдоггүй. Компанийн өртөж болох томоохон санхүүгийн эрсдэл нь доорх байдалтай байна.

29.1. Зах зээлийн эрсдэл

Компани санхүүгийн хэрэглүүрүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжаас мөн зээлийн эрсдэл үүснэ.

29.2. Гадаад валютын эрсдэл

Компани нь уул уурхайн бүтээгдэхүүний төлбөр тооцооны гүйлгээг гадаад валютаар хийдэг. Гадаад валютын ханшийн эрсдэлд өртөх нь анх ам.доллар, юаниар хийгдсэн компанийн гадаадад хийсэн борлуулалт, ам.доллароор хийгдсэн худалдан авалт, ам.доллар, юаниар хийгдсэн дэнчингийн мөнгөн гүйлгээ, үлдэгдлээс үүдэн бий болдог байна.

Гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах үүднээс компанийн гадаад валютаар орох орлогыг тухай бүр болон сарын эцэст Монгол банкнаас зарласан албан ханшид хөрвүүлэн бүртгэдэг.

Валютын эрсдэлд өртөж буй гадаад валютаар хийгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дор харуулав. Доорх дүнг хаалтын ханшаар монгол төгрөг рүү хөрвүүлж удирдлагадаа тайлагнасан байна:

Ангилал	ам.доллар	юань
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл		
Санхүүгийн хөрөнгө		
- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	701,515,545	75,236,809
- Дансны болон бусад авлага	450,248	30,253
Санхүүгийн өр төлбөр		
- Дансны болон бусад өглөг		
- УУБ-ний арилжааны дэнчин	692,897,246	74,873,911
Цэвэр дүн	9,068,547	393,151
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл		
Санхүүгийн хөрөнгө		
- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	811,253,334	84,628,706
- Дансны болон бусад авлага	1,259,389	75,230
Санхүүгийн өр төлбөр		
- Дансны болон бусад өглөг	223,400	-
- Зээл	797,725,206	83,237,639
Цэвэр дүн	14,564,117	1,466,297

Ам.доллар болон юанийн эсрэг төгрөгийн 10% (2023: 10%) –ийн өсөлт ба бууралтад үзүүлэх Компанийн мэдрэмжийг доорх хүснэгтээр харуулав. 10% (2023: 10%) нь гадаад валютын ханшийн боломжит өөрчлөлтөд өгөх удирдлагын үнэлгээг харуулдаг. Мэдрэмжийн шинжилгээнд зөвхөн одоогийн гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлс, гадаад валютын ханшийн 10% -ийн (2023: 10%) өөрчлөлт дэх тайлант хугацааны эцэст хийсэн нь хөрвүүлэлтийн тохируулга багтана.

Хэрэв төгрөг ам.доллар болон юанийн эсрэг 10% -аар (2023: 10%) чангарвал, дараах нөлөөг үзүүлэх болно:

Мянган төгрөгөөр	Тайлант оны ашиг, алдагдал		Өмч	
	Ам.доллар	Юань	Ам.доллар	Юань
2024 оны 12 сарын 31-ний байдлаар	(906,854)	(39,315)	(906,854)	(39,315)
2023 оны 12 сарын 31-ний байдлаар	(1,456,411)	(146,630)	(1,456,411)	(146,630)

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд

2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Гадаад валютын эрсдэлд өртөх байдал нь тайлант жилд гадаадад хийсэн гүйлгээний хэмжээнээс хамааран зөрүүтэй байна. Гэсэн хэдий ч дээрх шинжилгээ нь валютын эрсдэлд өртөх Компанийн байдлыг харуулж байна.

29.3. Зээлжих эрсдэл

Зээлжих эрсдэл нь компанид санхүүгийн эрсдэл үүссэний улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдэлийг харуулдаг. Компанийн хувьд энэхүү эрсдэлийн нөлөөлөл нь дансны авлага, өрийн хэрэглүүр гэх мэт өөр өөр санхүүгийн хэрэгслээс үүсдэг. Дараах санхүүгийн хэрэглүүрийн дансны үнээр хамгийн их зээлжих эрсдэлийг харуулав:

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Санхүүгийн хөрөнгө дансны үнээр		
- Банкн дахь харилцах болон хугацаатай хадгаламж	816,117,554	902,582,815
- Дансны авлага	3,085,468	2,017,926
Нийт дүн	819,203,022	904,600,741

Банкан дахь харилцах болон хугацаатай хадгаламж

Банкин дахь мөнгөний зээлжих эрсдэлийг томоохон банк, санхүүгийн байгууллагад байршуулах замаар удирддаг.

Moody's Investors Service/Standard & Poor's-ийн үнэлгээгээр банкин дахь харилцах болон хугацаатай хадгаламжийн зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
B2	816,117,554	-
B3	-	902,582,815
Дүн	816,117,554	902,582,815

Дансны авлага

Компани дансны авлага нь томоохон санхүүгийн бүрэлдэхүүн бүхий зүйлсийг агуулаагүй тул тэдгээрийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (найдваргүй авлагын зардал) тооцохдоо СТОУС 9-ийн дагуу хялбаршуулсан загварыг ашигладаг.

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ дансны авлагын цуглуулагдах хугацаанд үндэслэн үнэлдэг. Тэдгээр авлагыг хугацаа хэтэрсэн хоногоор нь бүлэглэдэг.

Найдваргүй авлагын зардлыг бүртгэхдээ Шууд аргыг хэрэглэдэг. Энэ арга нь авлага цугларах боломжгүй нь тодорхой болсон үед хэрэглэнэ. Энэ нь үл цуглуулагдах хэмжээгээр шууд хөрөнгийн данснаас зардлын дансанд шилждэг. Найдваргүй авлагын хэмжээг тодорхойлж шийдвэрлэх хүртэл бүртгэлд тусгахгүй.

Найдваргүй гэж тогтоосон авлагуудыг шүүхийн шийдвэр, хуулийн байгууллагын нотолгоог үндэслэн тухайн авлагын шинж чанар, хэмжээнээс хамааран Захирлын зөвлөлийн болон ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлүүлсний дараа авлагыг данснаас бүр мөсөн хасаж бүртгэлд тусгана.

Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2024 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

2024 оны 12 сарын 31-ний байдлаар	Дансны авлагын хугацаа хэтэрсэн хоног				
	Хугацаа хэтрээгүй	13-24 сар	25-60 сар	60 сараас дээш	Нийт
Нөөц байгуулах %	0%	25%	50%	100%	
Дансны үнэ	3,085,468			209,129	3,294,597
Байгуулсан нөөцийн дүн	-	-	-	209,129	209,129

2023 оны 12 сарын 31-ний байдлаар	Дансны авлагын хугацаа хэтэрсэн хоног				
	Хугацаа хэтрээгүй	13-24 сар	25-60 сар	60 сараас дээш	Нийт
Нөөц байгуулах %	0%	25%	50%	100%	
Дансны үнэ	2,017,926			232,347	2,250,273
Байгуулсан нөөцийн дүн	-	-	-	232,347	232,347

Найдваргүй авлагын нөөцийн 2024 оны өөрчлөлт дараах байдалтай байна:

2023 оны 01 сарын 01-ний найдваргүй авлагын нөөцийн үлдэгдэл	246,567
Тайлант хугацаанд нэмж байгуулсан нөөц	-
Тайлант хугацаанд буцаасан нөөц	(14,220)
2023 оны 12 сарын 31-ний найдваргүй авлагын нөөцийн үлдэгдэл	232,347
Тайлант хугацаанд нэмж байгуулсан нөөц	-
Тайлант хугацаанд буцаасан нөөц	(23,218)
2024 оны 12 сарын 31-ний найдваргүй авлагын нөөцийн үлдэгдэл	209,129

2024 онд Бүртгэлтэй хувьцаат компанид үзүүлэх үйлчилгээний хөлс 15,434 мянган төгрөг, Гишүүнд компанид үзүүлэх үйлчилгээний хөлс 7,784 мянган төгрөгийн найдваргүй гэж үзэн нөөц байгуулсан авлагыг шүүхийн байгууллагад хандан шийдвэрлүүлсний дагуу шүүхийн шийдвэрийг үндэслэн авлагыг сэргээн, авлагыг барагдуулсан тул найдваргүй нөөцүүдийг нийт 23,218 мянган төгрөгөөр бууруулсан.

29.4. Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь компани хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх эрсдэл юм.

Компанийн бодлого нь үйл ажиллагааны болон зээлийн үйлчилгээтэй холбоотой төлбөрийг барагдуулахад хангалттай мөнгөн хөрөнгө болон түргэн борлогдох хөрөнгөтэй байх оновчтой хөрвөх чадварын удирдлагын бодлого хэрэгжүүлэх юм.

Дараах хүснэгтээр гэрээнд заасан эргэн төлөгдөх хугацаатай үүсмэл бус санхүүгийн өр төлбөрүүдийг төлөх Компанийн үлдсэн гэрээний хугацааг харуулав. Компани төлөх шаардлагатай эхний өдөр санхүүгийн өр төлбөрийн дискаунтчилаагүй мөнгөн гүйлгээнд үндэслэн уг хүснэгтийг гаргасан.

2024 оны 12 сарын 31-ний байдлаар	Богино хугацаат			Урт хугацаат
	6 сараас бага	6 сараас 1 сар	1-5 жил	5-с дээш жил
Дансны болон бусад өглөг	82,545	15,004	-	-
УУБ-ний арилжааны дэнчин	767,771,157	-	-	-
Нийт	767,853,702	15,004	-	-

2023 оны 12 сарын 31-ний байдлаар	Богино хугацаат			Урт хугацаат
	6 сараас бага	6 сараас 12 сар	1-5 жил	5-с дээш жил
Дансны болон бусад өглөг	266,433	-	-	-
УУБ-ний арилжааны дэнчин	880,962,845	-	-	-
Нийт	881,229,278	-	-	-

Компани нь хөрвөх чадварын эрсдэл ялангуяа мөнгөний эх үүсвэр, дансны авлагыг үнэлэх, удирдахад санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг авч үздэг. Компанийн мөнгөний эх үүсвэр, Дансны авлага нь эргэлтийн мөнгөн урсгалын шаардлагаас их байна. Дансны болон бусад авлагын мөнгөн урсгал нь бүгд 12 сарын дотор төлөгдөхөөр хүлээгдэж байна.

30. Бодит үнэ цэнийн хэмжилт

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд бодит үнэ цэнийн шатлалаар гурван түвшинд ангилна. Эдгээр гурван ангиллыг бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан орцуудын ач холбогдолд үндэслэнэ.

Түвшин 1: Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан тодорхойлно;
Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ;
Түвшин 3: Зах зээлийн ашиглаж болох өгөгдөл тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ашигладаг.
Дараах хүснэгтээр 2024 оны хувьд бодит үнэ цэнийг хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийн шатлалыг түвшин тус бүрээр харуулав.

2024 оны 12 сарын 31-ний байдлаар	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Санхүүгийн хөрөнгө				
Дансны болон бусад авлага *	-	3,085,468	-	3,085,468
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	816,117,554	-	816,117,554
Санхүүгийн хөрөнгийн дүн	-	819,203,022	-	819,203,022
Санхүүгийн өр төлбөр				
Дансны өглөг	-	97,549	-	97,549
Цэвэр бодит үнэ цэнэ	-	97,549	-	97,549

Дараах хүснэгтээр 2023 оны хувьд бодит үнэ цэнийг хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийн шатлалыг түвшин тус бүрээр харуулав.

2023 оны 12 сарын 31-ний байдлаар	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Санхүүгийн хөрөнгө				
Дансны болон бусад авлага *	-	2,017,926	-	2,017,926
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	-	902,582,815	-	902,582,815
Санхүүгийн хөрөнгийн дүн	-	904,600,741	-	904,600,741
Санхүүгийн өр төлбөр				
Дансны өглөг	-	266,433	-	266,433
Цэвэр бодит үнэ цэнэ	-	266,433	-	266,433

30.1. Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилт

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн шатлалын түвшинг 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

2024 оны 12 сарын 31-ний байдлаар	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Үндсэн хөрөнгө:				
–Барилга, байгууламж	-		4,657,796	4,657,796
–Дуусаагүй барилга	-	1,671,772	-	1,671,772
–Тээврийн хэрэгсэл	-	155,634	-	155,634
–Тавилга эд хогшил	-	91,753	-	91,753
–Компьютер, бусад хэрэгсэл	-	253,493	-	253,493
–Машин, тоног төхөөрөмж	-	497,700	-	497,700
Биет бус хөрөнгө:				
– Компьютерийн программ хангамж	-		6,282,033	6,282,033
–Газар эзэмших эрх	-	-	10,580,921	10,580,921
–Бусад биет бус хөрөнгө	-	181,587	-	181,587

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн шатлалын түвшинг 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

2023 оны 12 сарын 31-ний байдлаар	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Нийт
Үндсэн хөрөнгө:				
–Барилга, байгууламж	-		4,764,677	4,764,677
–Тээврийн хэрэгсэл	-	5,513	-	5,513
–Тавилга эд хогшил	-	111,961	-	111,961
–Компьютер, бусад хэрэгсэл	-	329,200	-	329,200
–Машин, тоног төхөөрөмж	-	241,711	-	241,711
Биет бус хөрөнгө:				
–Компьютерын программ хангамж	-		6,374,765	6,374,765
–Газар эзэмших эрх	-	-	10,580,921	10,580,921
–Бусад биет бус хөрөнгө	-	43,267	-	43,267

Үндсэн хөрөнгийг тайлангийн өдрөөр дахин үнэлээгүй бөгөөд анхны өртгөөр тайланд толилуулагдсан. Удирдлага нь тайлангийн өдөр болон худалдан авах өдрийн байдлаарх бодит үнэ цэнэд материаллаг өөрчлөлт гараагүй гэж үзсэн.

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн бус хөрөнгийн бодит үнийн хэмжилтийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Үнэлгээний хөрөнгөтэй ижил төстэй объектын борлуулалтын зах зээлийн мэдээлэл олдоцтой, найдвартай байсан учраас зах зээлийн хандлагаар үнэлэхэд ашиглах орц мэдээлэл нь СТОУС13-д тодорхойлсон "2-р түвшний орц мэдээлэл" гэж үзсэн.

Компани 2022 онд биет болон биет бус хөрөнгүүддээ хөрөнгийн мэргэжлийн үнэлгээний байгууллагаар дахин үнэлгээ хийлгэсэн.

МХБ-ийн оффисыг доорх газрын хамт зах зээлийн аргаар 15,492 сая төгрөг гэж үнэлэн, үүнээс газрын үнэлгээг тогтоохдоо барилга газрын зах зээлийн аргаар тогтоосон үнэлгээнээс барилгын өртгийн аргаар хийсэн үнэлгээг хасаж 10,568 сая төгрөгөөр тооцоолон, бүртгэсэн байна. Компанийн удирдлага эдгээр хөрөнгийн үнэлгээ нь зах зээлийн үнэлгээтэй ойролцоо байна гэж үзсэн.

31. Капиталын удирдлагын бодлого, журам

Компанийн капиталын удирдлагын бодлогын зорилго нь:

Компани цаашид үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадавхыг хангах

Тухайн бүтээгдэхүүн үйлчилгээний холбогдох эрсдэлийн түвшинг үндэслэн тэдгээрийн үнийг оновчтой тогтоох замаар хувьцаа эзэмшигчдэд зохистой өгөөжийг хүртээх юм.

Компанийн зорилго нь капитал, санхүүжилтийн харьцааг зохистой түвшинд барих юм.

Санхүүгийн хараат байдлаас зайлсхийх үр ашигтай санхүүгийн бүтцийг бий болгохын тулд удирдлага Компанийн капиталын шаардлагыг үнэлнэ. Компани капиталын бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, хөрөнгийн эрсдэлийн шинж чанарыг харгалзан тохируулга хийдэг. Капиталын бүтцийг бий болгож, тохируулахын тулд Компани хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашгийн дүнд залруулга хийж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг буцаах, шинээр хувьцаа гаргах, эвсэл өр төлбөрөө бууруулахаар хөрөнгө борлуулах зэрэг арга хэмжээ авна.

Компанийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав:

Мянган төгрөгөөр	2024 оны 12 сарын 31-ний байдлаар	2023 оны 12 сарын 31-ний байдлаар
Нийт эздийн өмч	73,222,882	44,079,811
Хасах: мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Дэнчин хассан)	48,346,397	21,619,970
Капитал	24,876,485	22,459,841
Нийт эздийн өмч	73,222,882	44,079,811
Нэмэх: Дансны болон бусад өглөг	333,534	607,737
Бүх санхүүжилт	73,556,416	44,687,548
Капитал, санхүүжилтийн харьцаа	0.34	0.50

Тайлант жилийн цэвэр орлого 24,868 сая төгрөг буюу 2.7 дахин өссөнөөр эздийн өмч нэмэгдэж капитал, санхүүжилтийн харьцаа буурсан байна.

32. Тайлагналын үеийн дараах үйл явдал


Тайлагналын өдөр буюу 2024 оны 12 дугаар сарын 31 болон энэхүү тайланг баталгаажуулсан өдөр хоорондын хугацаанд ямар нэгэн залруулагдах эсвэл үл залруулагдах томоохон гүйлгээ гараагүй болно.

33. Орчуулга

Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд Монгол болон Англи хувилбар хооронд зөрүү гарвал, Монгол хувилбарыг дагах болно.

34. Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт

2024 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон санхүүгийн тайланг 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр удирдлага батлав.



Д.Тогтохбаяр
ТУЗ-ийн дарга

Огноо: 2025.04.16



Б.Дөлгөөн
Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Огноо: 2025.04.16



Х.Эрдэнэбүрэн
Санхүүгийн газрын захирал

Огноо: 2025.04.16